



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №13



2018 оны 4-р сарын 16-20-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **236** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 53(22.4%) галзуугийн эрсдэлд өртсөн, 176(74.6%) хачигт халдвар, 2 (0.8%) бэтэг, 1(0.4%) хумхаа, 4(1.7%)-ийг боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 48 сум, Нийслэлийн 5 дүүрэгт хачгаар дамжих халдварын 176 мэдээлэгдсэн нь 16%-иар, эпидемиологийн 15-р долоо хоногт 85 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





Хэрэгжүүлж буй арга хэмжээ:

- Голомтот нутгийн хүн амд хачигт энцефалитын 8550 хүн тун хачигт энцефалитын вакциныг хүргүүлж, эхний тунгийн хамралт 86.7%, давтан тунгийн хамралт 48% байна.
- Хачгаар дамжих халдвараас сэргийлэх инфографик бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байна.
- Фэйсбүүк хуудсаар ярилцлага хийж түгээж байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Сэлэнгэ аймгийн 22 сум, Нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 53 тохиолдол бүртгэгдсэн байна. эпидемиологийн 15-р долоо хоногт эрсдэлд өртсөн 1 тохиолдол нэмж бүртгэгдсэн. (График 1)



1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 3 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 4 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит хүлээн аваад байна.

1.5 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн.

Хариу арга хэмжээ:

- Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан.
- Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2018 оны гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (*БЗД, БГД, ХУД, *СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 15 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

ХОЁР. Тухайн долоо хоногт бүртгэгдсэн зоонозын шалтгаант үйл явдлын мэдээ

Монгол улсад

Шүлхий өвчин:

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг багийн “Тал булаг” гэдэг газар 4-р сарын 12-ны өдөр малчин айлын 4 үхэрт мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч УМЭАЦТЛ-ийн шинжилгээгээр батлагдсан байна.

Хариу арга хэмжээ: ОБЕГ

- 4-р сарын 13-ны өдөр тус сумын засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон.
- Голомтот нутгийн 38 өрхийн 528 үхрийг вакцинжуулж, өвчилсөн 83 үхрийг устгасан.

Төв аймгийн ОБХ-ээс авсан мэдээгээр: ЗӨСҮТ

- Голомтот нутгийн 95 хүнд биеийн ерөнхий үзлэг хийж, 2500 иргэдэд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийв.



Эх сурвалж: ОБЕГ

Шүлхий өвчин:

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Хад багийн “Хадны ташуу” гэдэг газар 4-р сарын 13-ны өдөр малчин айлын 8 үхэрт мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч УМЭАЦТЛ-ийн шинжилгээгээр батлагдсан байна.

Хариу арга хэмжээ:

- 4-р сарын 14-ны өдөр тус сумын засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон.
- Голомтот нутгийн 35 малыг тусгаарласан.



Эх сурвалж: ОБЕГ

Мал, амьтны галзуу өвчин:

Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Өлзийт хошуу багийн “Чацарганын-Ам” гэдэг газар 2018 оны 4-р сарын 19-ны өдөр малчин айлын 1 адуунд мал амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээгээр галзуу өвчнөөр өвчилсөн болох тогтоогдсон байна.

Хариу арга хэмжээ:

- Тус суманд хязгаарлалтын дэглэм тогтоосон.
- 1 өрхийн 1 адууг устгаж, ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Эх сурвалж: ОБЕГ

Дэлхий дахинд

Шүлхий өвчин:

БНХАУ-ын Линхиа хотын Гансу дүүрэгт мал амьтны шүлхий өвчин бүртгэгдэж, 35 үхрийг устгаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуугийн өвчин.

Хонг Конг улсын Яй Цэйм Монг дүүрэгт байрлах Юн По тэжээвэр шувууны дэлгүүрт шувууны томуугийн H5N6 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, 2834 шувууг устгасан байна.

Хариу арга хэмжээ:

- Тус дүүргийн тэжээвэр шувууны дэлгүүрийг 21 хоногийн хугацаатай хаасан.
- Тус бүсэд хязгаарлалтын дэглэм тогтоож хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна.



Эх сурвалж:ДАЭМБ

Шар чичрэг өвчин:

Бразил улсад 2017 оны 4-р сарын 01-нээс, 2018 оны 4-р сарын 10-ны хооронд шар чичрэг өвчний 1127 тохиолдол батлагдаж, 331 нас баралт бүртгэгдсэн байна.

Эх сурвалж: Promed

Мал, амьтны галзуу өвчин:

Малайз Сарабак, Кучинг хотын дүүргүүдэд мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж, 320 нохой өртөмхий байснаас, 14 нохойг устгаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж:ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Того улсын Ломи хотын Мартитиме мужид шувууны томуугийн H5N1 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, 5001 шувуу өртөмхий байснаас, 3629 шувуу өвчилж үхэн, 1372 шувууг устгасан байна. Голомтот хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж:ДАЭМБ

Африкийн гахайн халуурал өвчин:

Латви улсын Жанпилс Муниспалит хотын Жанпилс гахайн аж ахуйд 1 гахай өвчилж үхсэн байна.

Эх сурвалж:ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Өмнөд Африк улсын Мадибенг хотын Хойд баруун мужид шувууны аж ахуйд, шувууны томуугийн H5N8 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, 41012 шувуу өртөмхий байснаас, 584 шувуу өвчилж үхсэн байна. Голомтот хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж:ДАЭМБ